

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХЭНТИЙ
АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2016 ОНЫ АЖЛЫН
ТАЙЛАН**

2016.12.22

Нэгдүгээр бүлэг: Удирдлага зохион байгуулалтын талаар

Үндэсний Аудитын Газрын харьяа Хэнтий аймгийн Аудитын газар нь 2016 онд “АУДИТЫГ ТӨЛӨВЛӨГДСӨН ХУГАЦААНД, ЧАНАРТАЙ ХИЙЖ, АУДИТЫН САЙН ТАЙЛАН ГАРГАНА” гэсэн зорилт дэвшүүлсэн.

Үндэсний аудитын газрын хэтийн төлөвлөгөө болон 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан аймгийн Аудитын газрын үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг боловсруулан хамт олны хурлаар хэлэлцүүлэн ТЕЗ-тай үр дүнгийн гэрээ байгуулан баталгаажуулсан.

Байгууллагын үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөнд аудитын ажил үйлчилгээний талаар 9 зүйлийн 48 арга хэмжээ, удирдлага зохион байгуулалтын талаар 6 зүйлийн 19 арга хэмжээ, хүний нөөцийн ажлын талаар 2 зүйлийн 8 арга хэмжээ, мэргэжлийн тасралтгүй сургалтын талаар 5 зүйлийн, 8 арга хэмжээ, авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын талаар 2 зүйлийн 4 арга хэмжээ, мэдээллийн ил тод байдал, олон нийттэй харилцах ажлын талаар 3 зүйлийн 10 арга хэмжээ, мэдээллийн техник, технологийн аюулгүй, бэлэн байдлын талаар 3 зүйлийн 10 арга хэмжээ, санхүү, нягтлан болох бүртгэл, тайлагналын талаар 4 зүйлийн 20 арга хэмжээ, архив, албан хэрэг хөтлөлтийн талаар 3 зүйлийн 12 арга хэмжээ, эрүүл мэнд-спортын талаар 8 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн.

Энэхүү зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 9, жолооч 1 нийт 11 орон тоотой ажиллалаа. Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу Тэргүүлэх аудитор аудитын менежер, аудитор/шинжээчидтэй төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаа.

Ажиллагсадын цагийн бүртгэлийг цахим системд шилжүүлж, сар тутам ажлын цагийн ачааллыг тооцсон ба нийт 13253.27 цаг зарцуулсаны 2175:53 цаг нь илүү цагаар ажилласан байна. Мөн нийт 2082 хүн/өдөр ажиллахаас 217 хүн/ өдөр чөлөөтэй, 48 хүн/өдөр өвчтэй байж, ажилласан нийт цагийг ажлын өдөрт шилжүүлбэл 1817 хүн/өдөр ажилласан байна.

Санхүүгийн аудитыг 5, гүйцэтгэл, нийцлийн аудитыг 3 хүний бүрэлдэхүүнтэй багаар зохион байгуулж, баг тус бүрийг ахлах аудиторoor ахлуулан, аудитын чанар, үр өгөөжид тавих хяналтыг аудитын менежерт бүрэн хариуцуулан ажиллаа. Харин байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал болох нягтлан бодогч, архив-албан хэрэг хөтлөх ажилтан болон хүний нөөц, мэдээлэл-олон нийттэй харьцах, мэдээллийн технологийн аюулгүй, бэлэн байдал, эрүүл мэнд-спортын талаарх чиг үүргийг хавсран гүйцэтгүүлж, нярав-жолоочтой хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилласнаар нэг хүнд ногдох дотоод ажлын ачааллыг бууруулж чадлаа. Байгууллагын дотоод чиг үүргийг хэрэгжүүлж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг бүрэн хэрэгжүүлж, төлөвлөсөн арга хэмжээ, ажлыг амжилттай зохион байгуулсан ажилтнуудад 494.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.

Аймгийн Аудитын газар нийт 123 аудит хийхээр төлөвлөснөөс 117 аудитыг гүйцэтгэж, ЯАГ-аас өгсөн чиглэлээр 2 санхүүгийн тайлангийн аудитыг хийгээгүй.

2016 онд ҮАГ-ын удирдамжаар 4, аймгийн ИТХ-ын захиалгаар 1 буюу нийт 5 гүйцэтгэлийн аудит, ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 5, аймгийн ИТХ-ын захиалгаар 3 буюу нийт 8 нийцлийн аудит хийсэн.

Тайланд онд хийсэн гүйцэтгэл, нийцэл болон санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6279.3 сая төгрөгийн 587 алдаа, зөрчил илэрснээс улсын төсвийн орлого бүрдүүлэлтэй холбоотой 77.7 сая төгрөгийн 9, орон нутгийн төсвийн бүрдүүлэлтэй холбоотой 36.4 сая төгрөгийн 29, төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой 660.1 сая төгрөгийн 24, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 3643 сая төгрөгийн 156, арвилан хэмнэлт, үр ашигтай холбоотой 161.4 сая төгрөгийн 34, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 1486.9 сая төгрөгийн 226, дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 116.6 сая төгрөгийн 56, худалдан авалтай холбоотой 33.4 сая төгрөгийн 43, бусад 63.4 сая төгрөгийн 10 алдаа, зөрчлийг илрүүлсэн байна. Илрүүлсэн алдаа, зөрчлийн 54 хувийг санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлжээ.

Тайланд онд хийсэн гүйцэтгэл, нийцэл болон санхүүгийн тайлангийн аудитаар нийт 335 зөвлөмж өгснөөс 89.0 хувь буюу 298 нь хэрэгжиж, үлдэх хувь нь хэрэгжих шатандаа байна.

2016 онд Гүйцэтгэлийн аудитаар 4.5 сая төгрөгийн 1, нийцлийн аудитаар 7.2 сая төгрөгийн 3, санхүүгийн тайлангийн аудитаар 32.0 сая төгрөгийн 57 төлбөрийн акт тогтоож, өмнөх оны үлдэгдэл ороод 28.3 сая төгрөгийг улс болон орон нутгийн төсөвт орууллаа. Мөн тайлант онд илэрсэн зөрчлийг арилгуулахаар гүйцэтгэлийн аудитаар 599.9 сая төгрөгийн 12, нийцлийн аудитаар 1040.8 сая төгрөгийн 56, санхүүгийн тайлангийн аудитаар 1203.8 сая төгрөгийн 52 албан шаардлагыг буюу нийт 2844.5 сая төгрөгийн албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэнээс 99 хувийг хэрэгжүүлсэн дүнтэй байна. .

2016 онд санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэл авсан, төрийн албан хаагчийн албан үүргээ хангалтгүй биелүүлсэн нийт 28 холбогдох албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах албан тоот, албан шаардлагыг хүргүүлснээс 82 хувь буюу 23 нь хэрэгжиж, үлдэх 5 саналыг хэрэгжүүлээгүй байна.

Тайланд онд гүйцэтгэлийн аудитаар 10.7 сая төгрөгийн 14, санхүүгийн тайлангийн аудитаар 1109.8 сая төгрөгийн 215, нийцлийн аудитаар 40.3 сая төгрөгийн 14, судалгаа шинжилгээний ажлаар 1080.7 сая төгрөгийн 28 буюу нийт 2241.5 сая төгрөгийн 271 үр өгөөжийг бүртгэж, тооцоолон, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн. Энэ нь 2016 онд аймгийн аудитын газрын авсан санхүүжилтийн 1 төгрөгийн хариуд 10 төгрөг 46 мөнгөний үр өгөөжийг бий болгож, өмнөх оноос 3 төгрөг 62 мөнгөөр өссөн дүнтэй байна.

Аудитын дүнд бий болгосон 271 үр өгөөжийн 173 санхүүгийн, 98 санхүүгийн бус үр өгөөж байна.

Хоёрдугаар бүлэг: Санхүүгийн аудитын талаар

Аймгийн Аудитын газар 2016 онд 107 санхүүгийн тайлангийн аудит хийхээр төлөвлөснөөс 105 санхүүгийн аудитыг 5 аудитор, 4 аудитын компаниар гүйцэтгүүлж, нийт 145 өдөр зарцуулан 442.7 илүү цаг ажилласан байна.

Санхүүгийн аудитад хамрагдвал зохих нийт 229 байгууллагын санхүүгийн тайлангийн 14-т нь итгэл үзүүлж, 105-д нь дүгнэлт гарган, 43-ыг нь түүвэрт хамруулж, 67-д нь аудит хийлгүй өнжөөсөн.

Тайланд онд нийт 105 байгууллагын 2015 оны санхүүгийн тайланд аудит хийсний 53-ыг нь аймгийн Аудитын газар, 52-ыг нь аудитын 4 компаниар гүйцэтгүүлсэн. Үүнээс аймгийн Аудитын газар 33 төсвийн шууд захирагч, 1 төсөл сан, 4 орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн санхүүгийн тайланд, 1 аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, 13 сумын төрийн сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд, аудитын компаниуд 48 төсвийн шууд захирагч, 3 төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 төсөл сангийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн аудитаар өгсөн дүгнэлтийн 87.6% нь “зөрчилгүй”, 10.5% нь “хязгааралтай”, 1.9% нь “татгалзсан” санал дүгнэлт эзэлж байна.

Тайлант онд хийсэн санхүүгийн аудитаар нийт 3405.0 сая төгрөгийн 323 алдаа, зөрчил илрүүлсэн байна. Үүнд:

- Орлого бүрдүүлэлттэй холбоотой зөрчил 32 зөрчлийн 94.5 сая төгрөг
- Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой 4 зөрчлийн 4.2 сая төгрөг
- Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой 146 зөрчлийн 2994.0 сая төгрөг
- Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой 24 зөрчлийн 15.0 сая төгрөг
- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 62 зөрчлийн 125.5 сая төгрөг
- Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 44 зөрчлийн 107.4 сая төгрөг
- Худалдан авалттай холбоотой 1 зөрчлийн 1.4 сая төгрөг
- Бусад 10 зөрчлийн 63.4 сая төгрөг байна.

Үүнээс гадна санхүүгийн тайланд 1511.0 сая төгрөгийн 86 алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой алдаа зөрчил нь нийт илэрсэн алдаа зөрчлийн тоогоор 45.2 хувийг, мөнгөн дүнгээр 87.9 хувийг эзэлж байгаа нь цаашид нягтлан бодогчийн ажлын хариуцлагыг сайжруулах, тогтвортой ажиллуулахад анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

Тайлант онд санхүүгийн аудитаар нийт 32.0 сая төгрөгийн 57 төлбөрийн акт тогтоож, өмнөх оны үлдэгдлийг оруулаад 2016 онд 27.6 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулан, улс, орон нутгийн төсөвт оруулсан байна.

Тайлант онд санхүүгийн аудитаар 1203.8 сая төгрөгийн 52 албан шаардлага хүргүүлсний 1190.0 сая төгрөгийн 46 албан шаардлага бүрэн хэрэгжсэн ба үлдэх хэсэг нь буюу 1.1 хувь нь хэрэгжээгүй байна.

Мөн “Төрийн аудитын тухай” хуулийн 28-р зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулах 28 албан шаардлага хүргүүлсний 19 нь хэрэгжсэн байна.

Тайлант онд санхүүгийн аудитаар өгсөн 275 зөвлөмжийн 256 буюу 93.1 хувь нь хэрэгжсэн дүнтэй байна. Өгсөн зөвлөмжийг ангилалаар нь авч үзвэл:

- Арвилан хэмнэх, үр нөлөөг сайжруулах талаар -20 зөвлөмж
- Бүртгэл тайлагналтай холбоотой-105 зөвлөмж
- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 113 зөвлөмж
- Дотоод хяналтыг сайжруулах талаар 33 зөвлөмж
- Бусад 4 зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

Тайлант онд санхүүгийн аудитаар 1109,8 сая төгрөгийн 127 санхүүгийн, 88 санхүүгийн бус үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлээ.

МУ-ын Ерөнхий аудиторовын 2015 оны 10 дугаар сарын 06-ны А/249 тоот тушаалын 7 дугаар хавсралтаар нийт 53 төсөвт байгууллага, аж ахуйн нэгжийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд нэр бүхий 4 хувийн аудитын компани тус бүртэй “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгүүлэх журам”-ын дагуу “Аудитын ажил гүйцэтгүүлэх 2016 оны гэрээ”-г байгуулан, гүйцэтгэх ажлын даалгавар өгч ажиллаа.

Аудитын компаниар гүйцэтгүүлсэн 52 санхүүгийн тайлангийн аудитын 26.9 хувь буюу 14-ийг “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК, 25.0 хувь буюу 13 -ыг “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК -ийн Хэнтий салбар, 25.0 хувь буюу 13-ыг “Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК, 23.1 хувь буюу 12-ыг “Өндөрхаан Итгэл Аудит” ХХК тус тус гүйцэтгэсэн байна.

Аудитын компаниудын ирүүлсэн санал, гүйцэтгэсэн ажлын баримыг үндэслэн нийт 52 санхүүгийн тайлангийн 84.6 хувь буюу 44-т нь “Зөрчилгүй санал дүгнэлт”, 11.5 хувь буюу 6-д нь “Хязгаарлалттай санал дүгнэлт”, 3.9 хувь буюу 2-т нь “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт өглөө.

Аудитын компаниар гүйцэтгүүлсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1152.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсний 41.2 хувийг “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК, 20.0 хувийг “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК -ийн Хэнтий салбар, 5.6 хувийг “Өндөрхаан Итгэл Аудит” ХХК, 33.2 хувийг “Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК-ниуд тус тус илрүүлжээ.

Хувийн аудитын компанитай байгуулсан “Аудитын ажил гүйцэтгүүлэх 2016 оны гэрээ”-г дүгнэх ажлыг 2016 оны 4 дүгээр сарын 27-ноос 5 дугаарын 26-ныг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэн, гэрээ дүгнэсэн танилцуулгыг компаниудад хүргүүлж ажиллаа.

Аймгийн аудитын газар ТШЗ, ТТЗ, ТЕЗ болон төсөл сан, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргах, итгэл үзүүлэх, түүвэрт хамруулах байгууллагуудын жагсаалтыг гаргаж, ҮАГ-т хүргүүлэн МУ-ын Ерөнхий аудиторовын 2016 оны А/72 тоот тушаалаар баталгаажуулав. Жагсаалтад итгэл үзүүлэх 15, түүвэрт хамруулах 33, ТШЗ 40, ТТЗ 15, ТЕЗ 1, ТС 3, Төрийн болон ОНӨ 7, ХАК-иар 57 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхээр тусгагдсан.

МУ-ын Ерөнхий аудиторовын тушаалаар батлагдсан жагсаалтыг үндэслэн аудитор, шинжээч нарын хуваарийг баталж, 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудитыг хийж, 81 байгууллагын төлөвлөлтийн үе шатны ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Завсрын аудитаар 9 суманд очиж ажиллав.

Гуравдугаар бүлэг: Гүйцэтгэлийн аудитын талаар

Аймгийн Аудитын газар 2016 онд 7 гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөсний 1 нь аймгийн ИТХ-ын захиалгаар хийгдсэн.

Тайланд онд ҮАГ-ын төлөвлөгөө, хөтөлбөрөөр 4 аудит гүйцэтгэхээс “Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”, “Хэнтий аймгийн 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”, “Улсын нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалт, хуваарилалт, үр дүн”, “УИХ болон аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуулийн зардлын гүйцэтгэл” сэдэвт гүйцэтгэлийн 4 аудитыг хийж, 864.2 сая төгрөгийн 32 зөрчил илрүүлэн, 4.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 9 албан шаардлага, хариуцлага тооцох 2 санал хүргүүлж, 22 зөвлөмж өгч, 10.7 сая төгрөгийн 14 үр өгөөж

тооцууллаа. Харин “Улсын төсвөөс эргэж төлөгдөх нөхцлөөр олгосон хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлт, үр дүн”-д хийх аудитын төлөвлөгөө, хөтөлбөр ирээгүй болно.

Тайлант онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 825.2 сая төгрөгийн 74 алдаа, зөрчил илрүүлсэн байна. Үүнд:

- Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой 14 зөрчлийн 133.6 сая төгрөг
- Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой 4 зөрчлийн 539,5 сая төгрөг
- Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой 2 зөрчлийн 11.3 сая төгрөг
- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 7 зөрчлийн 132.8 сая төгрөг
- Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 7 зөрчлийн 8.0 сая төгрөг
- Худалдан авалттай холбоотой 40 зөрчлийн 0 сая төгрөг

Тайлант онд гүйцэтгэлийн аудитаар 599.9 сая төгрөгийн 12 албан шаардлага хүргүүлж, 100 хувь хэрэгжсэн байна.

Тайлант онд гүйцэтгэлийн аудитаар өгсөн 22 зөвлөмж өгсөнөөс 10 хувь хэрэгжсэн байна.

Өгсөн зөвлөмжийг ангилалаар нь авч үзвэл:

- Арвилан хэмнэх, үр нөлөөг сайжруулах талаар -4 зөвлөмж
- Бүртгэл тайлагналтай холбоотой-5 зөвлөмж
- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 5 зөвлөмж
- Дотоод хяналтыг сайжруулах талаар-8 зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

Тайлант онд гүйцэтгэлийн аудитаар 10.7 сая төгрөгийн 5 санхүүгийн, 9 санхүүгийн бус үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүллээ.

Дөрөвдүгээр бүлэг: Нийцлийн аудитын талаар

Аймгийн Аудитын газар 2016 онд 8 нийцлийн аудит хийхээр төлөвлөснийн 2 нь аймгийн ИТХ-ын захиалгаар хийгдэх юм.

Тайланд онд УАГ-ын төлөвлөгөө, хөтөлбөрөөр “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт”, “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, ЗГ-ын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар МСДС, сумдын байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаа, зарцуулалт-д нийцлийн аудит хийж, 1766.2 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, зөрчлийн арилгах 56 албан шаардлага, хүргүүлж, 36 зөвлөмж өгч ажиллалаа.

Тайлант онд нийцлийн аудитаар 1032.4 сая төгрөгийн 55 албан шаардлага хүргүүлсний 1031.4 сая төгрөгийн 54 албан шаардлага хэрэгжсэн байна.

Тайлант онд нийцлийн аудитаар өгсөн 22 зөвлөмж өгснөөс 100 хувь хэрэгжсэн байна.

Тайлант онд нийцлийн аудитаар 40.3 сая төгрөгийн 13 санхүүгийн, 1 санхүүгийн бус үр өгөөжийг бий болгож, харилцагч байгууллагаар нь хүлээн зөвшөөрүүллээ.

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч УАГ-ын төлөвлөгөө, удирдамжаар орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшигч, нам, эвслийн мөрийн хөтөлбөрт 4 сарын 27-ноос 29 –нд аудит хийлээ.

А1 .Аудитад 6 нам, 1 бие даан нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө ирүүлсэн ба “Сонгуулийн тухай” хуулийн 67.4 дэх заалттай нийцээгүй нийт 11 заалтыг залруулах 5 албан шаардлага хүргүүлж, хуульд заасан шаардлагыг хангуулж ажилласан.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр, тооцоо судалгааг үндэслэлтэй гаргах талаар зөвлөмжийг 6 намуудад хүргүүлсэн.

Аудитад Хөдөлмөрийн Үндэсний Нам, Монгол Ардын Нам, Иргэний Зориг-Ногоон Нам, Ардчилсан Нам, Монгол Ардын Хувьсгалт Нам, Монгол Үндэсний Ардчилсан Нам, бие даан нэр дэвшигч Д.Дашдондогийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг холбогдох хууль, баримт бичигтэй нийцсэн байна гэсэн дүгнэлтийг өгч, аймгийн Сонгуулийн хороонд албан бичгээр хүлээлгэн өгсөн.

А2. УАГ-аас ирүүлсэн аргачлал зөвлөмжийн дагуу Орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшигч, нам, эвслийн зардлын дээд хэмжээг “Сонгуулийн тухай” хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3-т заасан хугацаанд тогтоон, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, хуульд заасан хугацаанд аймгийн сонгуулийн хороо болон олон нийт, хэвлэл мэдээлэлд мэдээлж ажиллалаа.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн зардлыг нам эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 120.0 сая төгрөгөөр, нэр дэвшигчдийн зарцуулах зардлын дээд хэмжээг сумын сонгогчийн болон өрхийн тоо, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарч 7.0-29.0 сая төгрөгөөр тогтоолоо.

А3. Аймгийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам эвсэл, бие даан нэр дэвшигчидэд 1 сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, 2 сая ба түүнээс дээш хандив өгсөн хуулийн этгээдийг 2016/11/19-ний дотор нийтэд зарлах ажлыг гүйцэтгэж, аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуульд оролцсон 3 нам, 86 дэвшигчээс 2 нам, 75 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн байна. Намуудад 2.0 сая төгрөг ба түүнээс дээш хандив өгсөн хуулийн этгээд байхгүй, 1.0 сая төгрөгийн хандив өгсөн 3 иргэн байна.

75 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд нийт 208,3 сая төгрөг төвлөрч, 2 нэр дэвшигчид тус бүрт 2 сая төгрөгийн хандив өгсөн нэг хуулийн этгээд, 1.0 сая төгрөгөөс дээш хандив өгсөн 25 иргэн байна.

Сонгуулийн хорооноос ирүүлсэн намуудын болон нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянах явцад “Сонгуулийн тухай” хуулийн 47,5 заалтыг зөрчиж сонгуулийн зардлын данс нээлгээгүй нэр дэвшигч 1, 59,2 заалтыг зөрчиж дансны хуулга ирүүлээгүй нэр дэвшигч 27, 59,3 заалтыг зөрчиж банкнаас дансны тайлан ирүүлээгүй 47 хүн, 50,4 заалтыг зөрчиж хандив өгсөн иргэний регистрийн дугаар тавиагүй 16, 59.2.1 заалтыг зөрчиж нийт 25,5 сая төгрөгийг өөрийн дансанд төвлөрүүлээгүй 10 нэр дэвшигч байлаа.

Сонгуульд оролцсон нам, эвсэл болон нэр дэвшигч нарт хандив өгсөн иргэн, хуулийн этгээдийг жагсаалтаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлаж, дүнг аймгийн ИТХ-д хүргүүлсэн.

Б1. Сумын ИТХ-ын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ: Сумын ИТХ-ын 2016 оны сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтоож, аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2016/07/18-ны өдрийн 23 тоот тушаалаар баталгаажуулсан.

Сумын ИТХ-ын сонгуульд нам, эвслийн тус бүрийн зарцуулах зардлын дээд хэмжээг хүн ам, нутаг дэвсгэрийн байршлаас хамааруулан сум бүрээр 7.0-27.0 сая төгрөгөөр, тойрогт нэр дэвшигчийн зарцуулах зардлын дээд хэмжээг баг бүрээр 5.0-14.0 сая төгрөгөөр тогтоосон.

Б2.Сумын ИТХ-ын 2016 оны сонгуульд оролцох 4 намаас 18 сумын 39 сонгуулийн мөрийн хөтөлбөр, 5 суманд 12 бие даан нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө ирүүлжээ. Аудитын явцад илэрсэн “Сонгуулийн тухай” хуулийн 67,4 дэх заалттай нийцээгүй нийт 74 заалтыг залруулах, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн тооцоо судалгаа гаргаагүй зөвлөмжийг намуудад өгч ажилласан.

Сумын ИТХ-д оролцох намуудын нийт 39 мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийг 2016/08/20-нд, бие даагч нарын 12 мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийг 2016/09/02-нд гаргаж, хүлээлгэн өгсөн

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар 234 байгууллагын судалгааг 1,2-р маягтаар судалгааг нэгтгэн дүгнэж, 3,4,5-р маягтаар судалгааг бөглөж, аудитын тайланг холбогдох байгууллага болон ҮАГ-т файлаар болон цаасаар хүргүүллээ. Аудитаар 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 1582.6 сая төгрөгийн худалдан авалтыг мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш 1159.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш 13928.5 сая төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй, 216.7 сая төгрөгийн тушаал, шийдвэрийг мэдээлээгүй, гэрээгээр үүрэг гүйцэтгэгч ТББ нь 157.1 сая төгрөгийн санхүүжилтийг мэдээлээгүй зэрэг нийт **17043.9** сая төгрөгийн гүйлгээтэй холбоотой мэдээллийг байршуулаагүй ба хугацаа хоцроосон, мэдээллийг хагас дутуу оруулсан зэрэг зөрчил илрүүлснээс холбогдох ТЕЗ, албан тушаалтанд зөрчлийг арилгах 4 зөвлөмж, алдаа зөрчил гаргасан 26 байгууллагын холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг ТЕЗ-д хүргүүллээ.

Тавдугаар бүлэг: Аймгийн ИТХ-ын хүсэлтээр болон өөрийн санаачлагаар хийсэн аудитын талаар

Аймгийн ИТХ-ын захиалгаар “Орон нутгийн байгаль хамгаалах сангуудын хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, үр дүн”- д гүйцэтгэлийн аудит хийж, 187.8 сая төгрөгийн 4 зөрчил илрүүлэн, 2 зөвлөмж өгч ажилласан байна.

Мөн захиалгаар “Мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр олгосон хандив, тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгийн зарцуулалт”, “Соёлын байгууллагын өөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”, “МАА-н чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт”-д нийцлийн аудитыг хийж, 109.4 сая төгрөгийн 2 зөрчлийг илрүүлэн 8.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага хүргүүлж, 10 зөвлөмж өгсөн байна.

Тайланд онд аймгийн БОАЖГ, Хэрлэн сумын “Баялаг хурх” ХХК-ниас ирүүлсэн хүсэлтийг судлан, хариу тайлбар хүргүүлж, 3 зөвлөмж өгч ажиллаа.

Мөн өөрийн санаачлагаар санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, акт, албан шаардлагын биелэлтийг шалгаж, давтан аудитыг хийж гүйцэтгэллээ. Тухайн аудитад давхардсан тоогоор 7 аудитор, шинжээч оролцож, 58 өдөр ажилласан байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2017 оны төсвийн төсөлд санал дүгнэлт боловсруулж, аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцууллаа. Төсвийн төсөлд төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр 425.8 сая төгрөгийн 3 санал, төсвийн орлогыг нэмэгдүүлэх 544.0 сая төгрөгийн 3 саналыг боловсруулж саналыг хүргүүлэхэд төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх талаар оруулсан саналыг 100 хувь хүлээн авч, СТСХ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны төсвийн төсөлд тусгасан бөгөөд аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлагдсан байна.

Зургаадугаар бүлэг: Дотоод ажлын талаар

6.1. Хүний нөөцийн ажлын талаар:

1. Улсын архивын үзлэгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Аудитын газрын архив-албан хэрэг хөтлөлт хариуцсан ажлыг хавсран гүйцэтгэх ажилтны ажлын байрны тодорхойлолтын шинэчлэн боловсруулж, баталгаажуулав.
2. Төрийн албан хаагчийн бүрэлдхүүн, хөдөлгөөний 2015 оны тайлангийн “Хүний нөөцийн мэдээний систем HRMS” программд ажиллагсдын 2015 оны мэдээллийг бүрэн оруулж, аймгийн ТАЗ-ийн салбар ажилтнаар хянуулан баталгаажуулсан.
3. Аймгийн аудитын газрын ажилтнуудын 1, 2, 3,4-р улирлын ажлыг Тэргүүлэх аудиторын тушаалаар баталсан “Улирлын ажлыг үнэлж, дүгнэх үзүүлэлтүүд”-ээр үнэлж, дүгнэн, ажлын үр дүнгээр урамшуулал олгов.
4. Тайлант онд шилдэг илтгэл, шилдэг тайлан шалгаруулах журам боловсруулан, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан шалгаруулалтыг аудитын менежер Б.Наранцэцэг, ахлах аудитор Н.Туяа, Х.Еркегүл нарын бүрэлдэхүүнтэйгээр үнэлгээг өгч шалгаруулав. Байгууллагын “Оны шилдэг тайлан”-гаар аймгийн ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайлан тэргүүн байранд, Орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлан дэд байранд тус тус шалгарч, шалгарсан аудитын тайланг бичсэн баг, шинжээч нарт батламж, мөнгөн урамшууллыг олгож, байгууллагын тэргүүн байранд шалгарсан оны шилдэг тайланг ҮАГ-ын шилдэг тайлан шалгаруулалтад явуулав.
5. Аймгийн аудитын газрын ажиллагсдын дэлгэрэнгүй судалгааг 2016 оны 4 дүгээр сарын 1-ний байдлаар гаргасан.
6. Ардын хувьсгалын 95 жилийн ойг тохиолдуулан 4 ажилтанг Сангийн яамны жуух бичиг, Санхүү банкны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулахаар материалыг бүрдүүлж, аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн боловч 1 ажилтны санхүүгийн байгууллагад ажилласан жил нь хүрээгүй шалтгаанаар материал нь буцаагдаж, бусад ажилтнууд шагнагдан, шагналын дагалдах мөнгөн урамшуулалд 120.0 мянган төгрөгийг олгоод байна.
7. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тухай мэдээг гаргаж, Хэнтий аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хугацаанд нь хүргүүлсэн. Тус мэдээгээр аудитын газрын ажилтнуудын ёс зүй зөрчсөн талаар өргөдөл, гомдол ирээгүй байна.
8. Амар тайван гэр бүлийн төлөө хамдтаа “45 хоногийн аяны ажлыг аймгийн ИТХ-ын ажлын албатай хамтарч зохион байгуулж, “Цахим орчин дахь хүчирхийллээс хэрхэн урьдчилан сэргийлэх, цахим гэмт хэрэг гэж юу вэ” гэсэн сэдэвт сургалтад 3 ажилтанг хамруулж, “Амар тайван гэр бүл” сэдэвт гар зургийн уралдааныг зохион байгуулахад оролцож, шүүгчээр ажилласан.
9. Батлагдсан бүтцийн хүрээнд ажиллаж буй албан хаагчдийн судалгааг Төрийн албаны салбар зөвлөлөөс ирүүлсэн хавсралт маягтаар гаргаж, Тэргүүлэх аудитороор баталгаажуулан 2016 оны 06 дугаар сарын эхний цалингийн цэсний хамт салбар зөвлөлд хүргүүлэв.
10. Ажиллагсдын ажилласан жилийн дэлгэрэнгүй судалгааг 2016 онд шинэчлэн гаргав. Судалгаагаар төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр олгох, шатлалыг ахиулах болон цалингийн шатлал, зэрэг дэв олгох, ахиулах дараагийн хугацаа нь болсон ажилтан байхгүй байна.

6.2. Мэдээллийн ил тод байдал, олон нийттэй харилцах ажлын талаар:

1. Аймгийн Аудитын газар орон нутгийн Хэнтий мэдээ сонинд 5 удаа мэдээлэл бэлтгэн өгч, 14 төрлийн мэдээлэл, нийтлэлийг хэвлүүлэн олон нийтийн хүртээл болгов.
2. ҮАГ-ын цахим сайтад 2015 оны ОНХС-ийн зарцуулалт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлан, Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, Хэнтий аймгийн 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, БХСангийн үйл ажиллагаа, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангуудыг байршуулж, аудитын талаарх бусад холбогдох 14 мэдээг байршуулж мэдээлсэн.
3. Аймгийн ИТХуралд нэр дэвшигч, нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтоосон тухай мэдээллийг орон нутгийн радио, телевиз, хэвлэл мэдээллийнхэнд хэвлэлийн бага хурал хийж, радио телевизээр мэдээлсэн.
4. Сумын хуралд нэр дэвшигч, нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтоосон тухай мэдээллийг орон нутгийн радио, телевиз, хэвлэл мэдээллийнхэнд хэвлэлийн бага хурал хийж, радио телевизээр мэдээлсэн.
5. СТА-д нөлөө үзүүлж болзошгүй иргэдийн болон бусдын шүүлжлэлтэй мэдээллийг цуглуулж, аудитад ашиглах боломжийг бүрдүүлэх зорилгоор сүлжээнд хэвлэлийн шүүмж мэдээ файл үүсгэн, мэдээг гаргаж, нутгийн хэвлэл, мэдээллээс аудиттай холбоотой мэдээллийг авч аудитад ашиглаж байна.
6. Хэнтийн мэдээ сонинд улирал бүр мэдээ бэлтгэн өгч, олон нийтэд мэдээллийг түгээсэн.
7. Байгууллагын facebook нээж, байгууллагын түүхийг оруулж, цаг үеийн мэдээг оруулж ажиллав.

6.3. Архив-албан хэрэг хөтлөлтийн талаар:

1. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны болон боловсон хүчний чиглэлээр 2016 оны эхний хагас жилд аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовын 41 тушаалыг бүртгэлд авч, хариуцсан ажилтан нэг бүрээр тушаалын хэрэгжилтийг гаргахад 97,8% нь хэрэгжиж, 1 тушаал хэрэгжээгүй байна.
2. УЗХ-ын тэмдэглэл 7, хамт олны хурлын тэмдэглэл 4-ыг хөтлөж баримтжуулаад байна. Удирдлагын зөвлөлийн хурлаар гүйцэтгэл болон нийцлийн аудитын 15 тайланг хэлэлцэн баталгаажуулсан байна.
3. Байгууллагын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гаргаж байгуулагад хөтлөгдөх хэргийг хадгалах хугацааны зүйлийн жагсаалт, хадгалах хугацааг тодорхойлж, албан тушаалтан нэг бүр дээр хөтлөгдөх хэргийг жагсаалтаар оруулж батлууллаа.
4. Тайлант хугацаанд ҮАГ болон бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн цаасаар болон цахимаар ирүүлсэн хариутай, хариугүй албан бичиг, и-мэйл өргөдөл гомдол, хүсэлт нийт 313 албан бичгийг бүртгэж, аймгийн Төрийн байгууллагын мэдээллийн цахим “Offshore” системээр холбогдох ажилтанд шилжүүлэн, шийдвэрлэлтийн мэдээг ажилтан нэг бүрээр гаргаж, улирал бүр Тэргүүлэх аудиторт танилцуулан ажиллаа.
5. Байгууллагаас явсан албан бичиг 293-ыг стандартын дагуу хэвлэж, холбогдох байгууллага, албан тушаалтанд зохих журмын дагуу хүргүүлээ
6. Албан бланкын бүртгэл хөтлөж, аудитор, шинжээчдэд шаардсан тоо хэмжээгээр шифрлэн олгож, аудитын гэрчилгээ, зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын 1 хувийг төрөл тус бүрээр нь хавтас нээн хадгалж байна.
7. Байгууллагын тамга тэмдгийг цоожтой шүүгээнд хадгалж, хариуцан ажиллаа.
8. Ажилтнуудад архивын бүрдэл хангасан баримтыг архивт шилжүүлэхэд бэлтгэх ажлын заавар өгч, архивын баримт үдэхэд заавал байх шаардлагуудыг загвар болгож танилцуулж, ХХНЖ-ийн дагуу ажилтнуудаас 2015 оны архивын баримт болон 2016 оны СТА-ын баримтыг хүлээн авах хуваарийг батлуулж, аудитор, шинжээч тус бүрт жагсаалтыг гаргаж өгсөн.

9. ХХНЖ-ийн дагуу Аудитын газрын 2015 оны дотоод ажлын болон санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын 66 баримтыг хүлээн авсан.
10. Аудитын газрын 2016 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан батлуулсан. Архивын баримтанд тооллого явуулах ажил, байнга, түр хадгалах баримтын данс, бүртгэл, устгах хэргийн актыг байгууллагын ББНШК болон төрийн архивын ББНШАЗК-оор хэлэлцүүлж, батлуулах ажил хийгдээгүй байна.

6.4. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын талаар:

1. Аудитын газрын нийт ажилчдад авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх, албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг хэрхэн гаргах талаар зөвлөгөө мэдээлэл өгч, 2015 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогоо мэдүүлсэн аудитын газрын 9 ажилтны ХАС, ХОМ-ийг цаасаар болон цахимаар хүлээн авч, мэдээ тайланг АТГ-ын цахим санд бүртгэн, хянан баталгаажуулж, тайланг ҮАГ-ын хүний нөөц хариуцсан шинжээчид хүргүүлсэн.
2. Аудитын чанарын хяналтыг хэрэгжүүлэх, санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудит хийхдээ болон өргөдөл гомдол шалгахдаа мэдэгдсэн ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл 171, ашиг сонирхлын зөрчилтэй мэдэгдэл 2-ийг тус тус бүртгэж, нийт 173 мэдэгдлийг АТГ-ын цахим сайтад шивж оруулан, цаасаар хадгалж байна.
3. Авилгын эсрэг хууль тогтоомж, дүрэм, журмыг ажилтнуудад сурталчилах ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газрын цахим сайтад тавигдсан мэдээлэлтэй тухай бүр танилцаж албан бичиг болон хууль, журамд оруулсан нэмэлт өөрчлөлтийг албан тушаалтнуудад мэдээлж, АТГ-аас эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан 4 заалт бүхий зөвлөмж, Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд гарсан зөвлөмжийн Аудитын газарт холбогдох хэсгийг танилцуулах хуудсаар нийт ажилтнуудад танилцуулах хуудсаар танилцуулан танилцуулан, аудитын газрын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, төрийн аудитын байгууллагын ёс зүйн дүрэм зэргийг байгууллагын дотоод мэдээллийн самбарт байршуулж ажиллагсдад мэдээллээ.
4. Хувийн аудитын компаниар аудит хийлгэх журам, 2016 онд гэрээт аудит хийхээр шалгарсан аудитын компанийн нэр, гүйцэтгэх ажлын жагсаалтыг гэрээт аудитын төлбөрийн хамт, АТГ-ын зөвлөмж, “Төрийн аудитын байгууллага аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх журам” зэргийг байгууллагын мэдээллийн самбарт байршуулан иргэдэд мэдээллээ.
5. Байгууллагын хэмжээнд зохион бүрдүүлж байгаа баримт бичиг буюу тушаал-18, зөрчил арилгуулах албан шаардлага -94, төлбөрийн акт-55, албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага-18, нийт 185 баримт бичгийн хууль зүйн үндэслэлд хяналтын хуудсаар хяналт тавьж ажиллаа.
6. Аудитын газарт ирүүлсэн байгууллагын дотоод өргөдөл, хүсэлт 15, иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол-2, аудит хийлгэх тухай -2, болон аудитын актын төлбөрийг сумын нэр заагдаагүй бусад орлогын дансанд оруулах тухай хүсэлтийг хүлээн авч, Тэргүүлэх аудиторт танилцуулан, холбогдох аудитор шинжээчид шилжүүлэн шийдвэрлүүлээ.
7. Нууцын зэрэглэлтэйгээс бусад аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил тод мэдээлэх ажлыг мэдээлэл хариуцсан ажилтан ҮАГ-ын цахим сайтад 16 удаа цаг үеийн мэдээллийг байршуулж, Хэнтийн мэдээ сонинд 8 удаа аудитын мэдээг нийтлүүлсэн байна.

6.5. Мэргэжлийн тасралтгүй сургалтын чиглэлээр

1. Ерөнхий мэдлэгийн сургалтын хүрээнд МТС-ын хүрээнд www.audit.mn бев сайтнаас тест бэлтгэн сорил шалгалтыг ажилтан бүрээс 7 хоног бүр тогтмол авч дүгнэн ажиллагсдын мэдлэгийн түвшинг ахиулах талаар анхаарч ажиллаа.
2. Гадаад хэлнээс орчуулга хийх санаачлага гараагүй тул ажилтан бүрт сургалтын гарын авлагаас¹ хуудас орчуулах материалыг хувиан өгч, хэрэгжилтэд бүрэн хийгдээгүй байна.
3. Ажлын байрны чиг үүргийн холбогдолтой сургалтын хүрээнд УАГ-ын СУГ-аас АДБОУС-ын сургалт зохион байгуулаглагдсан сургалтад аудитор шинжээч нарыг бүрэн хамрууллаа. Мөн дотоод сургалтын хүрээнд шинжээч Д.Эрдэнэбилэг “Багаар ажиллах ур чадвар”, Тэргүүлэх аудитор Ц.Энхтүвшин “Төрийн аудитын тулгуур зарчмууд”, аудитын менежер Б.Наранцэцэг АОУС 500 буюу “Аудитын нотлох зүйл”, АОУС 300 буюу “Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлт”. сэдвээр хичээл бэлтгэж, заалаа.
4. УАГ-ын САГ-аас зохион байгуулсан “Аудитад мэдээллийн технологийн ашиглах хөгжүүлэх зарим асуудлаар төрийн аудитын төв орон нутгийн аудиторчуудын дунд зохион байгуулах хэлэлцүүлэг” сургалтанд аудитор шинжээчдийг хамрууллаа.
5. Ахлах аудитор Х.Еркегүл магистр хамгаалах судалгааны эхний хэлэлцүүлэгт амжилттай оролцсон. Цахим тестийн сангаас тест бөглөх ажлын хүрээнд бүх аудитор, шинжээч нараас сард 2 удаа www.audit.mn бев сайтнаас тест бэлтгэн сорил шалгалт авч дүнг танилцуулан ажиллаа.
6. ММНБИ-ээс зохион байгуулдаг “эрх сунгах” сургалтад ахлах аудитор Н.Туяа, Х.Еркегүл нар хамрагдаж, шалгалт өгч хугацаагүй эрхтэй ММНБ-ийн гэрчилгээгээ гардан авсан болно.

6.6. Мэдээллийн технологийн чиглэлээр

1. Үндэсний Аудитын газраас баталсан мэдээллийн технологийн чиглэлийн “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”, “Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлийн үйл ажиллагааг зохицуулах журам”, “Компьютер техник, тоног төхөөрөмж болон дотоод сүлжээ, цахим шуудан ашиглалтын журам”-уудыг нийт ажилтнуудад танилцуулан мөрдөж ажиллаж байна.
2. 2016 оны 8 сард программын гэмтэл гарч ажиллахгүй болсон 6 компьютерийг засварлан хэвийн ажиллагаанд оруулсан ба мэдээллийн техник, тоног төхөөрөмжийн тооллогыг хагас жилийн байдлаар хийж гүйцэтгэлээ.
3. Санхүүгийн аудитын ажилтнуудын өрөөний принтерийг сүлжээний орчинд ажилладаг болгон 6 компьютерийг холбон ашиглалтгүй болсон Samsung 1660 принтерийг няравт хүлээлгэн өглөө.
4. Дотоод сүлжээний тоног төхөөрөмжийн хэвийн ажиллуулан, саатал гарсан тухай бүрд нь засварлан сүлжээний ажиллагааг хянаж ажиллалаа.
5. Аймгийн Аудитын газрын ажилтнуудын “audit.mn” сайтын “аудит оффис” цахим орчинд ажиллах бүртгэлийг баталгаажуулан бүртгэлжүүллээ.
6. Үндэсний Аудитын газраас ирүүлсэн “Bitdefender 2015” албан ёсны зөвшөөрөлтэй антивирусыг бүх 12 компьютерт суулган хамгаалалттай болгоод байна.
7. Аймгийн Аудитын газрын 12 компьютерийн нууцлалыг хадгалах үүднээс нууц кодтой болгон улирад бүр сольж хэвшээд байна.
8. 2016 оны туршид сервер компьютерийн болон ажилтнуудын өөрсдийн компьютерүүдийн нээлттэй фолдер, файлуудыг эрэмблэн, ашиглалтгүй файл, мэдээллийг тухай бүрд нь устгуулах, цэвэрлэх ажлыг зохион байгуулсан.
9. Дотоод сүлжээний тоног төхөөрөмжийн хэвийн ажиллуулан, саатал гарсан тухай бүрд нь засварлан сүлжээний ажиллагааг хэвийн хангаж ажиллалаа.

6.7. Бусад ажлын талаар:

1. Байгууллагын ажилтан албан хаагчдын бие бялдарыг чийрэгжүүлэх хамт олныг гэр бүлүүдтэй нь танилцуулах зорилгоор гэр бүлүүдийн дунд гар бөмбөгийн тэмцээнийг 5 удаа, ажиллагсдын дунд “Дугуйн аялал”-ыг амжилттай зохион байгуулж, ажиллаа.
2. Санхүүгийн тайлангийн аудит дууссантай холбогдуулан төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарын дунд анх удаа зохион байгуулсан 3 төрөлт спортын арга хэмжээ нь оролцогчдын дэмжлэг авч, цаашид жил бүр уламжлал болгохоор боллоо.
3. Нэгдсэн Вант Улс /Англи/-ын Үндэсний аудитын газраас Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын үйл ажиллагаанд хийж байгаа түншийн үнэлгээнд аймгийн ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит сонгогдож, аудитыг хийсэн багийн ахлагч ахлах аудитор Х.Еркегүл, шинжээч М.Чулуун-Эрдэнэ нар Англи улсын Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын менежер Корин Таннер, ахлах аудитор Анна Вожтал нарт аудиттай холбоотой асуудлаар тайлбар өгч, санал, бодлоо солилцож ажилласан.
4. Аймгийн Засаг даргаас ирүүлсэн албан бичгийн дагуу -“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр мянганы зам дагуу байрлах хайсанд мод тарих ажлыг зохион байгуулж, ажиллагсад 10 улиасыг худалдан авч, тарьсан.

Долдугаар бүлэг: Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл

1. УАГ-ын харьяа Хэнтий аймгийн аудитын газар нь 2016 онд нийт 214,3 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй 214,3 сая төгрөгийн санхүүжилттэй, 11 орон тоотойгоор ажиллаж 214,0 сая төгрөгийн гүйцэтгэл гарлаа.
2. 2016 оны санхүүгийн байдлын тайланд тайланд 0,3 сая төгрөгийн банкны үлдэгдэлтэй, 0,6 сая төгрөгийн авлагатай байна.
3. Байгууллагын 2015 оны санхүүгийн тайланд гэрээгээр аудит хийлгэж ЗӨРЧИЛГҮЙ дүгнэлт авсан.
4. Байгууллагын 2016 оны төсвийн төслийг 2015 оны 4 дүгээр сарын 30-нд боловсруулж төсвийн саналыг 475,1 сая төгрөгөөр гаргаж УАГ-т хүргүүлсэн.
5. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг самбарт байрлуулж, шилэн дансны нэгдсэн системд хуулийн дагуу мэдээ мэдээллийг оруулж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан.
6. 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд УАГ-т нэгтгүүлсэн болно.
7. 1,5 сая төгрөгийн авто гражийн барилга, 2,5 сая төгрөгийн 6 нэр төрлийн хөрөнгийг данснаас хасуулах санал хүргүүлж, УАГ-аас хүлээж авсан 10 нэр төрлийн 20 ширхэг хөрөнгийг данс бүртгэлд тусгахаар болов.

Наймдугаар бүлэг: Дүгнэлт, санал

1. Аймгийн аудитын газрын орон тооны хязгаарлагдмал байдал нь нэгдсэн төлөвлөгөө, удирдамжаар хийгдэх аудитад хүний нөөц дутагдаж, аудитын чанарт сөргөөр нөлөөлж байдаг тул нэг төрлийн аудитыг нэг цаг хугацаанд давхцуулахгүй байх талаар анхаарах
2. Аудитын журмууд шинэчлэгдэн гарч байгаатай холбоотой аймгийн Аудитын газрын аудитын менежерийн ажлын онцлог, аудитын багийн ахлагч буюу ахлах аудитор/шинжээчийн ажлын чиг үүргийг тодорхой болгож, шинэ зорилтыг хуучин

аргаар хэрэгжүүлэх нь амжилтанд хүрдэггүй тул тэднийг чадавхжуулах сургалт хамруулах.

3. Нэгдсэн удирдамжаар хийгдэж байгаа аудитын зардлыг хичээл, практикийн зардлын ангилалд тавьж өгвөл аудитад шаардагдах томилолт, шатахуунаас бусад зардлыг зохих журмын дагуу зарцуулах боломж нээгдэх юм.
4. Нэг удаагийн буцалтгүй тэтгэмж, урамшууллын зардал хүрэлцэхгүй байна. Манай байгууллагын хувьд төрөл садан нь таалал төгсөх, хүндээр өвчлөх, ар гэрийн орлого буурах тохиолдол энэ оны эхний хагаст 3 удаа гарсан боловч ЗГ-ын тогтоол, дотоод журмынхаа дагуу нэг ч удаа тусламж, дэмжлэг олгож чадсангүй.
5. Энэ жил Аудитын газрын үйл ажиллагаанд дараах ажлыг шинэ санаачлага болон нэвтрүүлж, үр дүнд хүрч байна.
 - a. Ажиллагсадын цагийн бүртгэлийг цахимжуулсан нь ажлын ачаалал, үр дүнг тооцох боломжийг бий болгосон
 - b. Улирал тутам ажиллагсадын ажлын үр дүнг тооцох журам гаргаж хэрэгжүүлсэн нь зохих үр дүнг гарч байгаа боловч төлөвлөгдсөн ажлын гүйцэтгэлийг цаг хугацаанд нь тайлагнахгүй байна.
 - c. Аудитор, шинжээчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор улирал тутам гадаад хэлнээс орчуулга хийх ажлыг зохион байгуулж байна. Гэвч орчуулгыг мэргэжлийн түвшинд найруулах талаар чадамж хүрэхгүй байна.
 - d. Хэрэглэгчийн сонирхол, хүсэлд нийцэх тайлан гаргах, ажиллагсадын судалгаа хийх, илтгэх чадварыг дээшлүүлэх зорилгоор 2 журам боловсруулан хэрэгжүүлж эхэллээ.
 - e. Дотоод ажил хариуцсан ажилтан гэсэн нэрийн дор нэг хүнд ногдож байсан ажлын ачааллыг багасгах зорилгоор 7 ажлын чиг үүрэгт хуваан аудитор, шинжээчид хуваарилсан нь аудит хийх ажилтан нэгээр нэмэгдэж, дотоод ажлын чанар, хүртээмж дээшлэв.